МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

# НЭГДСЭН ТАЙЛАН 2024

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН




MOVE
MONGOLIA

| | |
|---|---|
| Эмхэтгэлийг хянасан: | Э.Билэгт /ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/ |
| | О.Гэрэл /ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороо, Бодлого төлөвлөлтийн газрын дарга/ |
| Мэдээг бэлтгэсэн: | Аймаг, нийслэл, дүүргийн БТСГ, хороодын статистик хариуцсан мэргэжилтнүүд |
| Мэдээг нэгтгэн боловсруулсан: | Б.Ганзориг /ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороо, Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн/ |
| Газрын зургийн ArcGIS программ дээр ажилласан: | Ч.Цогзолмаа /Япон Улс, Токиогийн Олон улсын их сургууль. Өгөгдлийн шинжлэх ухааны магистр/ |
| Холбоо барих хаяг: | ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороо. |
| | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бага тойруу-55, Спортын төв ордон |

www.sport.gov.mn
https://sport.gov.mn/statistics
info@sport.gov.mn
Утас: 263696
Факс: 325234

© Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороо

# АГУУЛГА


1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД ........ 5

2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ ........ 12

    2.1. Спортын барилга байгууламж ........ 12

    2.2. Спортын гадаа талбай ........ 15

3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД ........ 18

    3.1. Шинээр цол авсан тамирчид ........ 18

    3.2. Цолтой шүүгчид ........ 23

    3.3. Үндэсний бөх ........ 24

    3.4. Цолтой сурын харваач ........ 26

    3.5. Цолтой уяач ........ 27

    3.6. Хурдан морь унаач хүүхэд ........ 29

4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД ........ 32

5. СПОРТЫН ТАМИРЧИД ........ 38

6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ ........ 42

7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД ........ 46

ХАВСРАЛТ ........ 52


## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

| | |
|---|---|
| ЗГХА | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг |
| БТСУХ | Биеийн тамир, спортын улсын хороо |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| БТСГ | Биеийн тамир, спортын газар |
| БТСХ | Биеийн тамир, спортын хороо |
| ЗСМ | Захиргааны статистик мэдээ |
| АСМ | Албаны статистик мэдээ |
| БТС | Биеийн тамир, спорт |

## ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хорооноос салбарын статистик тайлан мэдээ болох "Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2024"-ыг та бүхэндээ толилуулж байна.

Салбарын статистик мэдээг сайжруулах, бодлого боловсруулахад ашиглах, өгөгдлийн сан бүрдүүлэх чиглэлд 2017 оноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Биеийн тамир, спортын салбар 3-5 жилийн голлох үзүүлэлтийн динамик өөрчлөлтийг харуулсан эмхэтгэлийг долоо дахь жилдээ гаргаж байна. Тайлант онд "Биеийн тамир, спортын Улсын үзлэг тооллого-2024"-ыг орон даяар өрнүүлж, тайланг хэвлүүлэн тархаах хурлыг зохион байгуулав.

Энэхүү "Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2024"-д тусгагдсан статистикийн мэдээ нь Үндэсний статистикийн хороо хүлээн зөвшөөрч, албан ёсны маягтаар баталгаажсан тоо баримт бөгөөд эрхэм таны ажлын хэрэгцээг хангахуйц үнэ цэнтэй суурь мэдээлэл болно гэдэгт найдаж байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ

## 1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД

Монгол Улсад 2024 онд биеийн тамир, спортын нийт 33 байгууллага үйл ажиллагаа явуулж байгааг өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

ГРАФИК 1. Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллага, бүсээр




Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй ажиллагчид 2024 онд улсын хэмжээнд нийт 948 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 41 буюу 4.5%-аар өссөн байна. Нийт ажиллагчдын 295 (31.1%) нь нийслэлд, 213 (22.5%) нь Хангайн бүсэд, 206 (21.7%) нь Төвийн бүсэд, 125 (13.2%) нь Баруун бүсэд байгаа бол 109 (11.5%) нь Зүүн бүсэд байна.

ГРАФИК 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, бүсээр




Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 295 (31.1%) нь Улаанбаатарт, 67 (7.1%) нь Сэлэнгэ аймагт, 52 (5.5%) нь Баянхонгор аймагт байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Дундговь, Төв, болон Говьсүмбэр аймгуудын ажиллагчдын тоо өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй, харин Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл болон Хэнтий аймгуудын ажилчдын тоо нэмэгдэж, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь зэрэг аймгуудын ажиллагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

[1] Тайлант оны мэдээ бэлтгэхдээ суманд ажиллаж буй биеийн тамирын арга зүйч нарын тоог оруулсан болно.

ЗУРАГ 1. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, аймаг, нийслэл, хүйсээр




2024 он




2023 он




2022 он

Улсын дунджаар биеийн тамир, спортын 1 ажилтанд биеийн тамир, спортоор зонхилон хичээллэдэг 6–64 насны хүн ам 2022, 2023 онуудад тус бүр 3988, 3158 байсан бол 2024 онд 3076 болсон байна. Харин спортын ажилтан буюу албан тушаалын хувьд мэргэжилтэн, дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч, эмч нараас бүрдсэн 1 ажилтан тутамд 2022 онд дунджаар 9157, 2023 онд 6724 хүн ногдож байсан бол 2024 онд 6828 хүн ногдож байна.

ХҮСНЭГТ 1. Ажиллагчид, аймаг, нийслэлээр

| Бүс, аймаг, нийслэл | Биеийн тамир, спортын байгууллага | Ажиллагчид - Бүгд | Нэг ажилтанд ногдох хүн ам 2022 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам | Нэг ажилтанд ногдох хүн ам 2023 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам | Нэг ажилтанд ногдох хүн ам 2024 | Спортын нэг ажилтанд ногдох хүн ам |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **33** | **948** | **3988** | **9157** | **3158** | **6724** | **3076** | **6828** |
| **Баруун бүс** | **5** | **125** | **3271** | **6978** | **2761** | **5998** | **2804** | **5746** |
| Баян-Өлгий | 1 | 29 | 4215 | 9484 | 3949 | 12976 | 3183 | 6153 |
| Говь-Алтай | 1 | 18 | 2873 | 7182 | 2424 | 6060 | 2687 | 8061 |
| Завхан | 1 | 23 | 4015 | 12044 | 2899 | 7609 | 2640 | 6746 |
| Увс | 1 | 29 | 2155 | 3361 | 1841 | 2872 | 2485 | 4239 |
| Ховд | 1 | 26 | 3796 | 10122 | 3300 | 7591 | 2964 | 5505 |
| **Хангайн бүс** | **6** | **213** | **3538** | **11202** | **2340** | **5580** | **2394** | **6070** |
| Архангай | 1 | 43 | 3747 | 13382 | 2140 | 6599 | 1838 | 4390 |
| Баянхонгор | 1 | 52 | 2773 | 8872 | 1115 | 1738 | 1445 | 3130 |
| Булган | 1 | 23 | 2280 | 7694 | 1957 | 7270 | 2204 | 7243 |
| Орхон | 1 | 27 | 3756 | 12102 | 2972 | 9908 | 3352 | 8227 |
| Өвөрхангай | 1 | 36 | 3296 | 10486 | 2864 | 8853 | 2714 | 7516 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөвсгөл | 1 | 32 | 5944 | 15190 | 5064 | 12940 | 3652 | 10625 |
| **Төвийн бүс** | **7** | **206** | **2498** | **6230** | **2098** | **4698** | **2127** | **4816** |
| Говьсүмбэр | 1 | 23 | 753 | 2009 | 664 | 1174 | 676 | 1196 |
| Дархан-Уул | 1 | 27 | 4689 | 9804 | 3773 | 7889 | 3269 | 6304 |
| Дорноговь | 1 | 25 | 1828 | 5484 | 1563 | 4689 | 2460 | 8784 |
| Дундговь | 1 | 15 | 3110 | 7776 | 2552 | 5468 | 2568 | 5503 |
| Өмнөговь | 1 | 24 | 2893 | 4521 | 2565 | 4008 | 2793 | 5586 |
| Сэлэнгэ | 1 | 67 | 1931 | 7207 | 1602 | 4722 | 1343 | 3462 |
| Төв | 1 | 25 | 3710 | 7135 | 3083 | 5929 | 3095 | 6448 |
| **Зүүн бүс** | **3** | **109** | **2743** | **6152** | **2319** | **6016** | **1778** | **4037** |
| Дорнод | 1 | 21 | 3987 | 10466 | 3559 | 8897 | 3403 | 8933 |
| Сүхбаатар | 1 | 47 | 2095 | 4329 | 1451 | 3243 | 1182 | 3268 |
| Хэнтий | 1 | 41 | 2547 | 5640 | 2648 | 9457 | 1628 | 2902 |
| **Улаанбаатар** | **12** | **295** | **6123** | **11812** | **5033** | **9046** | **4825** | **9953** |

Нийт ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд улсын хэмжээнд нийт 948 ажиллагчид байгаагийн 477 (43.1%) нь эмэгтэй, 537 (56.9%) нь эрэгтэй ажиллагчид байна.

ГРАФИК 3. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, хүйсээр, аймаг, нийслэлээр




Нийт ажиллагчдыг албан тушаалаар авч үзвэл, нийт ажиллагчдын 330 (34.8%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 154 (16.2%) нь мэргэжилтэн мөн адил тооны дасгалжуулагч, 115 (12.1%) нь захиргаа болон санхүүгийн ажилтан, 58 (6.1%) нь удирдах албан тушаалын ажиллагчид байна. Харин 137 (14.5%) нь биеийн тамирын арга зүйч, эмч болон бусад албан тушаалын ажиллагчид байна.

ГРАФИК 4. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар




Нийт ажиллагчдын албан тушаалыг бүсээр авч үзвэл, Улаанбаатар, Хангайн болон Төвийн бүсүүдэд үйлчилгээ, аж ахуйн ажилтан давамгай байна. Мөн хамгийн олон мэргэжилтэн нийслэлд ажиллаж байна.

ГРАФИК 5. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, бүсээр




Үйлчилгээ, аж ахуйн ажилтны тоог аймгуудаар авч үзвэл нийт 330 ажилтан байгаагаас хамгийн олон буюу Сэлэнгэ аймагт 31, Баянхонгор аймагт 19, Сүхбаатар аймагт 25 тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, аймаг, нийслэлээр, 2024 он




Дасгалжуулагч болон биеийн тамирын арга зүйч нь энэ салбарт өндөр ач холбогдол бүхий мэргэжил юм. Тус 2 мэргэжлийн статистикийг аймаг, нийслэлээр авч үзвэл, Улаанбаатарт 28 дасгалжуулагч, Хэнтий аймагт 15, Сүхбаатар аймагт 11 арга зүйч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

ГРАФИК 6. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй дасгалжуулагч, аймаг, нийслэлээр




ГРАФИК 7. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж биеийн тамирын арга зүйч, аймаг, нийслэлээр



# 2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ

## 2.1. Спортын барилга байгууламж

Монгол Улсад 2024 онд биеийн тамир, спортын 46 барилга шинээр ашиглалтад орж нийт заалны тоо 1265 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 985 заал тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 28.4%-иар нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортын барилга нь хэд хэдэн төрлөөс бүрдэх бөгөөд нийт тооны дийлэнх хувийг “спорт заал” эзэлж байгааг доор зургаас харах боломжтой. Хэвийн үйл ажиллагаа явуулж буй 1219 заалны 893 (73.3%) нь “спорт заал” төрөлд хамаарч байна.

ЗУРАГ 3. Спортын барилга, өссөн дүнгээр




ГРАФИК 8. Спортын барилга, дунд эзлэх хувиар



**“Биеийн тамир спортын улсын үзлэг тооллого-2024”-ын тайлангийн эмхэтгэлээс**

## МОНГОЛ УЛСЫН НИЙТ СПОРТЫН ЗААЛНЫ ТОО

**1,541**







| | УЛААНБААТАР | БАРУУН БҮС | ХАНГАЙН БҮС | ТӨВИЙН БҮС | ЗҮҮН БҮС |
|---|---|---|---|---|---|
| Тогтмол | 378 | 43 | 24 | 63 | 5 |
| Улирлын чанартай | 321 | 164 | 231 | 226 | 86 |

ЗУРАГ 4. Спорт заал, аймаг, нийслэлээр, 2024




ХҮСНЭГТ 2. Спорт заал, дүүргээр, өссөн дүнгээр, 2024

| | |
|---|---|
| Улаанбаатар | 365 |
| Багануур | 10 |
| Багахангай | 4 |
| Баянгол | 57 |
| Баянзүрх | 58 |
| Налайх | 17 |
| Сонгинохайрхан | 46 |
| Сүхбаатар | 58 |
| Хан-Уул | 79 |
| Чингэлтэй | 36 |

ГРАФИК 9. Биеийн тамир, спортын барилга, бүсээр



## 2.2. Спортын гадаа талбай

Биеийн тамир, спортын зориулалт бүхий 74 гадаа талбай 2024 онд ашиглалтад орж нийт гадаа талбайн тоо 1127 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 777 гадаа талбай тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 45.0%-р нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5. Спортын гадаа талбай, өссөн дүнгээр

**ГАДАА ТАЛБАЙ**

** -Тухайн онд шинээр нэмэгдсэн*

**2021** — **934**
**75**
*Наадмын талбай: 3*
*Спорт талбай: 56*
*Явган зам: 3*
*Гүйлтийн зам: 4*
*Дугуйн зам: 5*
*Бусад: 4*

**2022** — **999**
**65**
*Спорт талбай: 49*
*Явган зам: 6*
*Цэнгэлдэх хүрээлэн: 2*
*Гүйлтийн зам: 2*
*Дугуйн зам: 2*
*Бусад: 4*

**2023** — **1 053**
**54**
*Спорт талбай: 40*
*Явган зам: 3*
*Цэнгэлдэх хүрээлэн: 3*
*Гүйлтийн зам: 1*
*Дугуйн зам: 3*
*Бусад: 4*

**2024** — **1 127**
**74**
*Наадмын талбай: 11*
*Спорт талбай: 43*
*Явган зам: 4*
*Гүйлтийн зам: 4*
*Дугуйн зам: 8*
*Бусад: 4*

ЗУРАГ 6. Спортын гадаа талбай, аймаг, нийслэлээр, 2024



**“Биеийн тамир спортын улсын үзлэг тооллого-2024”-ын тайлангийн эмхэтгэлээс**

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛБАЙН ТОО

# 1 950

Монгол Улсад 2022 онд хамгийн их буюу 95 гадаа талбай шинээр ашиглалтад орсон байна.

Монгол Улсын хамгийн анхны гадаа талбай 1947 онд спортын холимог төрлийн зориулалттайгаар ашиглалтад оруулсан байна. Энэхүү талбай нь одоогийн Увс аймгийн Улаангом сумын нутаг дэвсгэрт байх талбай бол үүний дараа 1950 онд Архангай аймгийн Төвшрүүлэх сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын 2 дахь гадаа талбайг спортын холимог төрлийн зориулалттайгаар ашиглалтад оруулжээ.




## НЭГ ХҮНД НОГДОХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, аймаг, нийслэлээр, 2024 он



ХҮСНЭГТ 3. Спортын гадаа талбай, дүүргээр, өссөн дүнгээр, 2023

| | |
|---|---|
| Улаанбаатар | 231 |
| Багануур | 9 |
| Багахангай | 26 |
| Баянгол | 16 |
| Баянзүрх | 32 |
| Налайх | 28 |
| Сонгинохайрхан | 17 |
| Сүхбаатар | 27 |
| Хан-Уул | 36 |
| Чингэлтэй | 40 |

Шинээр 2024 онд ашиглалтад орсон талбайн 16 (21.6%) нь Улаанбаатарт, 20 (27.0%) нь Баруун бүсэд, 19 (25.7%) нь Төвийн бүсэд, 13 (17.6%) нь Зүүн бүсэд, 6 (8.1%) нь Хангайн бүсэд байршилтай байна.

ГРАФИК 10. Шинээр ашиглалтад орсон биеийн тамир, спортын гадаа талбай, бүсээр



# 3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД

## 3.1 Шинээр цол авсан тамирчид

Монгол Улсад 2024 онд нийт 2391 тамирчид спортын цол авсан байна. Үүнээс 1836 (77.8%) нь эрэгтэй, 555 (23.2%) нь эмэгтэй тамирчид байна.

ГРАФИК 11. Шинээр цол авсан тамирчид, хүйсээр




Шинээр цол авсан тамирчдыг бүсээр авч үзвэл нийслэлд 984 (41.2%), Хангайн бүсэд 577 (24.1%), Баруун бүсэд 334 (14.0%), Төвийн бүсэд 323 (13.5%) нь харин Зүүн бүсэд 173 (7.2%), цолтой тамирчид байна.

ГРАФИК 12. Шинээр цол авсан тамирчид , бүсээр




Цол авсан тамирчдыг аймгаар авч үзвэл Орхон аймагт 220, Дорнод 87, Завхан 88, Ховд 80, Хөвсгөл 89 бүртгэгдсэн нь өндөр үзүүлэлт бүхий аймгууд байна.

ЗУРАГ 6. Шинээр цол авсан тамирчид, аймаг, нийслэлээр




2024 он




2023 он




Тамирчдыг цолоор нь авч үзвэл, 756 (44.9%) нь спортын дэд мастер, 735 (43.6%) нь спортын мастер, 193 (11.5%) нь олон улсын хэмжээний мастер цолтой тамирчид байна.

ГРАФИК 13. Шинээр цол авсан тамирчид , цолоор




Цолтой тамирчдын дийлэнх хувийг бүрдүүлж буй спортын дэд мастер цолтой тамирчдыг бүсээр харвал нийслэлээс гадна Хангайн бүсэд тэргүүлж байна.

ГРАФИК 14. Шинээр цол авсан тамирчид, цолоор, бүсээр




Спортын мастер цолтой тамирчдыг аймаг, нийслэлээр тодруулбал, Орхон аймагт 59, Хөвсгөл аймагт 15, Дорнод аймагт 28, Дундговь аймагт 10 тамирчид 2024 онд бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин Орхон аймагт 91, Хөвсгөл аймагт 48, Увс аймагт 25, Хэнтий аймагт 26, Дорнод аймагт 25, Дундговь аймагт 22, Говьсүмбэр аймагт 20 спортын дэд мастер бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. Шинээр цол авсан тамирчид, цолоор, аймаг, нийслэлээр






2023 он




2022 он

### 3.2. Цолтой шүүгчид

Монгол Улсад 2024 онд нийт 24 олон улсын шүүгч, 103 улсын цолтой шүүгчид бүртгэгдсэн байна. Нийт цолтой шүүгчдийн 72.0%-ийг эрэгтэй шүүгчид эзэлж байна. Мөн шинээр 2024 онд цол авсан шүүгчид нийслэл болон Хангайн болон Төвийн бүсэд давамгай байна.

ГРАФИК 15. Цолтой шүүгчид, бүсээр




Сүүлийн жилүүдэд биеийн тамир, спортын арга хэмжээ эрс өсөлттэй зохион байгуулагдаж байгаа бөгөөд үүнийг дагаад цолтой тамирчид, шүүгчид нэмэгдэх хандлагатай байна. Шүүгчдийн улсын цолтой ба олон улсын цолтой гэж ангилдаг, тэгвэл уг ангиллаар нийслэл болон Хангай, Төвийн бүсүүдэд хамгийн олон бүртгэгдсэн байна.

ГРАФИК 16. Цолтой шүүгчид, цолоор болон бүсээр



## 3.3. Үндэсний бөх

Монгол Улсад биеийн тамир спортын улсын тооллогоос хойш 2024 оны байдлаар өссөн дүнгээр улсын цолтой 443, аймгийн цолтой 2319, сумын цолтой 4781 бөхчүүд байна.

ГРАФИК 17. Үндэсний бөх, цол, өссөн дүнгээр




Улсын цолтой бөх өнгөрсөн онд 7-оор нэмэгдэж байсан бол энэ онд Говь-Алтай, Завхан, Ховд, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1, Увс болон Төв аймгуудад тус бүр 2 нийт 10 улсын цолтой бөх нэмэгдсэн байна.

ЗУРАГ 8. Улсын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2024 он




Энэ онд аймаг, сумын цолтой бөхчүүд өмнөх жилүүдийн өсөлттэй харьцуулахад аймгийн цолтой бөхчүүд нийслэлд 37, Архангай аймагт 10, Сэлэнгэ аймагт 5, бусад аймгуудад 1-5 бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 9. Аймгийн цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2024




2024 он

Сумын цолтой бөхчүүд нийслэлд 58 нэмэгдсэнээс гадна Архангай аймагт 34, Говь-Алтай аймагт 32, Завхан аймагт 48, Ховд аймагт 24 бусад аймгуудад 2-25 бүртгэгдэв.

ЗУРАГ 10. Сумын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2024




2024 он

### 3.4. Цолтой сурын харваач

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 175 цолтой сурын харваачид бүртгэгдсэнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 55, Төвийн бүсэд 41, Зүүн бүсэд 23, Баруун бүсэд 47, нийслэлд 9 тус бүр бүртгэгдсэн байна.

ГРАФИК 18. Сурын харваач, бүсээр




Нийслэлд 9 сур харваач бүртгэгдсэнээс гадна Ховд аймагт 18 буюу хамгийн олон сур харваач бүртгэгдсэн бол үүний дараагаар Булган аймагт 17, Өвөрхангай аймагт 15, Орхон аймагт 18 бусад аймагт 3-15 харваач бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 11. Сурын харваач, аймаг, нийслэлээр






2023 он




2022 он

### 3.5. Цолтой уяач

Монгол Улсын цолтой уяачдын тоо 2024 онд 442 бүртгэгдсэнийг бүсээр харвал Хангайн бүсэд 182, Төвийн бүсэд 115, Улаанбаатарт 2, Баруун бүсэд 145, Зүүн бүсэд 52 тус бүр цолтой уяач бүртгэгдсэн байна.

ГРАФИК 19. Цолтой уяач, бүсээр




Өмнөх онтой харьцуулахад цолтой уяачдын тоо даруй 229 уяачаар өссөн байна.

ЗУРАГ 11. Цолтой уяач, аймаг, нийслэлээр






2023 он




2022 он

## 3.6. Хурдан морь унаач хүүхэд

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 22948 хурдан морь унаач хүүхэд байгааг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 6625, Төвийн бүсэд 5126, Баруун бүсэд 4149, Зүүн бүсэд 5862, нийслэлд 1186 унаач хүүхэд бүртгэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад хурдан унаач хүүхдийн тоо энэ онд 7448 хүүхдээр нэмэгдсэн байна.

ГРАФИК 20. Хурдан морь унаач хүүхэд, бүсээр




Баянхонгор аймагт хурдан морь унаач 2049 хүүхэд, Дорнод аймагт 3862, Хөвсгөл аймагт 2120 бүртгэгдсэн нь хамгийн олон хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэн аймгууд байна. Бусад аймгуудын хувьд 500-1500 хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 12. Хурдан морь унаач хүүхэд, аймаг, нийслэлээр






2023 он




2022 он

## 4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД

Бие бялдрын түвшин тогтоох сорилд 2024 онд нийт 300425 иргэн хамрагдсан бөгөөд тэдгээрийн 145931 (48.6%) нь эрэгтэй, 154494 (51.4%) нь эмэгтэй байна. Сорилд хамрагдагчдыг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 74965 оролцогчоор буурсан байна.

Өнгөрсөн онуудад бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдын тоо огцом буурсан нь дэлхийн нийтийн хамарсан “Ковид-19” цар тахлын улмаас улс орон даяар “бүх нийтийн өндөржүүлсэн бэлтэн байдал”, “бүх нийтийн бэлэн байдал” зарлаж, нийтийг хамарсан арга хэмжээг тодорхой хугацаагаар хориглосон, мөн хорио цээрийн дэглэмийг мөрдөх шаардлагын улмаас олон хүнийг хамруулах боломжгүй болсон.

“Ковид-19” цар тахлын нөхцөл байдал хүндрээгүй орон нутагт биеийн тамир, спортын байгууллага хорио цээрийн дэглэмийг мөрдөн ажиллаж тодорхой түвшинд бие бялдрын түвшин тогтоох сорилд иргэдийн хамруулан ажилласан байна.

Харин 2021 оноос эхлэн нөхцөл байдал сэргэж биеийн тамир, спортын арга хэмжээг урьдын адил зохион байгуулж, бие бялдрын түвшин тогтоох сорилд олон нийтийг идэвхтэй хамруулж байна.

ГРАФИК 21. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд




Нийслэл Улаанбаатар болон Зүүн бүсэд 2020 онд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй бол 2021 онд мөн адил Зүүн болон Баруун бүсэд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй. 2022 оноос бүх засаг захиргааны нэгжид сорил авах үйл ажиллагаа зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2024 онд Улаанбаатар хотод зохион байгуулсан сорилд нийт 100908 (33.6%), Төвийн бүсэд 93783 (31.2%), Хангайн бүсэд 75347 (25.1%), Зүүн бүсэд 16439 (5.5%), Баруун бүсэд 13948 (4.6%) иргэн сорилд хамрагдсан байна.

ГРАФИК 22. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, бүсээр




Сорилд хамрагдсан иргэдийг аймаг, нийслэлээр авч үзвэл, нийслэлээс гадна Төв аймагт 46981 (15.5%), Хөвсгөл аймагт 35341 (11.8%), Дархан-Уул аймагт 13719 (4.6%), Архангай аймагт 10589 (3.5%) байна.

ЗУРАГ 13. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, аймаг, нийслэлээр






2023 он




2022 он

Хүйсийн тэнцвэрт байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл, ихэнх аймгийн хувьд ойролцоо тооны эрэгтэй, эмэгтэй хамрагдсан байна.

ГРАФИК 23. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, хүйсээр, аймаг, нийслэлээр




Бие бялдрын түвшин тогтоох сорилын үнэлгээг улсын хэмжээнд авч үзвэл, “А” үнэлгээ 21.3%, “В” үнэлгээ 30.4%, “С” үнэлгээ 23.3%, “D” үнэлгээ 14.2% , “F” үнэлгээ 10.8% байна. Өмнөх онтой харьцуулахад үнэлгээний хувь “А”- 1.7, “В”- 1.2, “С”- 0.3, “D”- 0.7 функтээр тус бүр буурсан бол, “F”- 4.0 функтээр өссөн байна.

ГРАФИК 24. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар




Улсын хэмжээнд “А” үнэлгээний 32.7%, “В” үнэлгээний 35.9%, “С” үнэлгээний 30.7%, “D” үнэлгээний 35.3%, “F” үнэлгээтэй 32.7%-ийг Улаанбаатар эзэлж байна. Харин Зүүн бүсийн хувьд үнэлгээний дүнгийн бүх ангиллын хамгийн бага хувийг эзэлж байна. Тодруулбал,

“A” үнэлгээний 4.9%, “B” үнэлгээний 4.1%, “C” үнэлгээний 5.9%, “D” үнэлгээний 7.5%, “F” үнэлгээтэй 7.0%-ийг эзэлж байгаа нь бусад аймгуудын хамрагдсан иргэдийн тооноос бага байгаатай холбоотой юм.

ГРАФИК 25. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар, бүсээр




Бүсийн үнэлгээг задлан харвал, Баруун бүсэд B, Төвийн бүсэд B, Хангайн бүсэд B, Зүүн бүсэд C үнэлгээ нь бусад үнэлгээтэй харьцуулахад өндөр хувийг эзэлж байна.

| 2024 | Нийт хамрагдагчдын улсын дүнд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| Баруун | 4.6% | 21.4% | 32.6% | 21.4% | 12.5% | 12.1% | 100.0% |
| Хангайн | 25.1% | 21.7% | 32.3% | 25.1% | 10.8% | 10.1% | 100.0% |
| Төвийн | 31.2% | 21.9% | 27.8% | 23.9% | 15.5% | 11.0% | 100.0% |
| Зүүн | 5.5% | 19.1% | 22.6% | 25.0% | 19.5% | 13.8% | 100.0% |
| Улаанбаатар | 33.6% | 20.7% | 32.6% | 21.3% | 14.9% | 10.5% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2023 | Нийт хамрагдагчдын улсын дүнд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| Баруун | 3.3% | 17.0% | 18.8% | 20.7% | 23.7% | 19.7% | 100.0% |
| Хангайн | 17.3% | 23.3% | 34.6% | 26.8% | 11.0% | 4.3% | 100.0% |
| Төвийн | 22.3% | 20.3% | 27.0% | 24.1% | 20.5% | 8.1% | 100.0% |
| Зүүн | 2.6% | 22.2% | 27.4% | 20.5% | 13.5% | 16.4% | 100.0% |
| Улаанбаатар | 54.5% | 24.3% | 33.7% | 22.7% | 13.3% | 6.0% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2022 | Нийт хамрагдагч-дын улсын дүнд эзлэх хувь | Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар | | | | | Үнэлгээний ангилал Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | B | C | D | F | |
| Баруун | 6.7% | 22.9% | 20.3% | 27.5% | 17.4% | 11.8% | 100.0% |
| Хангайн | 17.0% | 23.2% | 33.3% | 26.9% | 12.9% | 3.7% | 100.0% |
| Төвийн | 20.8% | 21.2% | 27.1% | 25.5% | 17.8% | 8.4% | 100.0% |
| Зүүн | 9.7% | 22.7% | 32.6% | 21.3% | 14.9% | 8.6% | 100.0% |
| Улаанбаатар | 45.8% | 24.4% | 34.4% | 23.2% | 12.4% | 5.7% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | **-** | **-** | **-** | **-** | **-** | |

Бие бялдрын түвшин тогтоох сорилын дүнгээр нийт хамрагдагчдын 72102 (24.0%) нь илүүдэл жинтэй байгаагийн 35775 (49.6%) нь эмэгтэй, 36327 (50.4%) нь эрэгтэй байна.

ГРАФИК 26. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний дүн, хүйсээр



## 5. СПОРТЫН ТАМИРЧИД

Монгол Улсад 2024 онд нийт 155275 тамирчин бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулбал 10.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 43797 (28.2%) нь, Төвийн бүсэд 29387 (18.9%) нь, Баруун бүсэд 21632 (13.9%) нь, Зүүн бүсэд 13358 (8.6%) байгаа бол Улаанбаатарт 47101 (30.3%) нь байна.

ГРАФИК 27. Тамирчид, бүсээр




Нийт тамирчдын дийлэнх хувийг буюу 73317 (47.2%) нь спорт тоглоом, 23890 (15.4%) нь үндэсний спорт, 19415 (12.5%) нь халз тулаан, хүчний спорт, 16237 (10.5%) оюуны спорт, 18890 (12.2%) хэмжигдэхүүнтэй спорт үлдсэн 3526 (2.3%) нь пара болон цэрэгжлийн спортын тамирчид эзэлж байна.

ГРАФИК 28. Тамирчид, спортын төрлөөр



Спортын төрлийг бүсээр авч үзвэл, спорт тоглоомын төрөл бүх бүсэд давамгайлж байна. Тодруулбал, Хангайн бүсэд 18495, Баруун бүсэд 11105, Төвийн бүсэд 13633, Зүүн бүсэд 5905, Улаанбаатарт 24179 тамирчин энэ төрөлд бүртгэгдсэн байна.

ГРАФИК 29. Тамирчид, спортын төрлөөр, бүсээр







Нийт тамирчдын тоог аймаг, нийслэлээр авч үзэхэд Хөвсгөл, Төв болон Улаанбаатар хотод хамгийн олон буюу тамирчинтай бол Говьсүмбэр, Завхан, Ховд, Сүхбаатар аймгуудад бусад аймгуудтай харьцуулаад цөөн тооны тамирчин бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 13. Тамирчид, аймаг, нийслэлээр




2024 он




2023 он


8090
Баян-Өлгий
3755
Увс
Хөвсгөл
12815
1211
Завхан
Ховд
1247
3619
Архангай
3555
Орхон
8916
Булган
Сэлэнгэ
3622
Дархан-Уул
2236
Улаанбаатар
41893
Төв
7022
Хэнтий
4170
6261
Дорнод
Говь-Алтай
2606
Баянхонгор
9611
Өвөрхангай
4425
3703
Дундговь
Говьсүмбэр
607
1983
Сүхбаатар
3030
Дорноговь
Өмнөговь
1500
Нийт тамирчид
600 - 1500
1500 - 3000
3100 - 4000
4100 - 7000
7100 - 10000
12000 - 41893

2022 он

## 6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

2019 оноос хойш зохион байгуулсан спортын арга хэмжээ даруй буурсан нь “Ковид-19” цар тахал дэгдэж Монгол Улсын засгийн газар, УОК-ын шийдвэрээр удаа дараагийн хөл хорио тогтоосонтой холбоотой бөгөөд 2024 онд 4122 арга хэмжээ зохион байгуулсан байна.

ГРАФИК 30. Биеийн тамир, спортын арга хэмжээ




ГРАФИК 31. Биеийн тамир, спортын арга хэмжээ, бүсээр




Нийт зохион байгуулсан нийт арга хэмжээний 1999 (48.5%) нь сумын, 1907 (46.3%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээ байна.

ГРАФИК 32. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар




Зохион байгуулагдсан арга хэмжээг чанараар нь авч үзвэл, нийт зохион байгуулсан олон улсын чанартай тэмцээний 51.7% нь Нийслэлд, улсын чанартай арга хэмжээний 30.6% нь, бүсийн чанартай арга хэмжээний 30.3% нь, аймаг нийслэлийн чанартай тэмцээний 56.7% нь тус бүр Төвийн бүсэд, харин сум дүүргийн чанартай тэмцээний 36.6% нь Хангайн бүсэд зохион байгуулагдсан байна.

ГРАФИК 33. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар, бүсээр



ЗУРАГ 13. Биеийн тамир, спортын арга хэмжээ, аймаг, нийслэлээр, 2024




Аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээг Дундговь, Өвөрхангай, Төв болон Орхон аймгуудад, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээг Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, болон нийслэлд хамгийн олон тоогоор зохион байгуулсан байна.

ЗУРАГ 14. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар






2024 он





2023 он





2022 он

## 7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд нийт 1325962 оролцогч хамрагдсан бөгөөд эдгээрийн 327540 (24.7%) нь Хангайн бүсэд, 225827 (17.0%) нь Төвийн бүсэд, 92215 (7.0%) нь Баруун бүсэд, 44515 (3.4%) нь Зүүн бүсэд, 635865 (48.0%) нь Улаанбаатарт хамрагдсан байна. Нийт оролцогчдын тоог өмнөх онтой харьцуулахад 310301 оролцогчдоор буюу 30.3% нэмэгдсэн байна.

ГРАФИК 34. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч




ГРАФИК 35. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, бүсээр




Нийт оролцогчдын 503210 (38.0%) нь сум, дүүргийн, 724844 (54.7%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээнд оролцсон байна.

ГРАФИК 36. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар




Оролцогчдыг бүсийн харьяаллаар авч үзвэл, Олон улсын чанартай арга хэмжээнд оролцогчдын 59.8% нь нийслэлийн, улсын чанартай арга хэмжээнд оролцогчдын 32.0% нь, бүсийн чанартай арга хэмжээний 30.6% нь Хангайн бүсийн, аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээний 50.0% нь, сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын 46.8% нь Улаанбаатарын оролцогчид байна.

ГРАФИК 37. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар, бүсээр



| 2024 | Улсын дунд эзлэх хувь | Чанар, дунд эзлэх хувиар | | | | | Чанар, Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| Баруун | 7.0% | 0.0% | 1.2% | 2.7% | 44.0% | 52.1% | 100.0% |
| Хангайн | 24.7% | 6.3% | 2.6% | 1.6% | 44.8% | 44.8% | 100.0% |
| Төвийн | 17.0% | 0.5% | 3.8% | 1.9% | 65.4% | 28.5% | 100.0% |
| Зүүн | 3.4% | 0.0% | 9.3% | 8.8% | 61.6% | 20.3% | 100.0% |
| Улаанбаатар | 48.0% | 5.1% | 0.7% | 0.2% | 57.0% | 37.0% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2024 | Улсын дунд эзлэх хувь | Чанар, дунд эзлэх хувиар | | | | | Чанар, Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| Баруун | 11.3% | 0.3% | 1.0% | 2.5% | 27.9% | 68.3% | 100.0% |
| Хангайн | 20.1% | 0.2% | 3.5% | 1.8% | 47.9% | 46.6% | 100.0% |
| Төвийн | 18.0% | 0.3% | 4.5% | 1.7% | 65.1% | 28.6% | 100.0% |
| Зүүн | 4.1% | 0.4% | 5.3% | 5.8% | 34.9% | 53.7% | 100.0% |
| Улаанбаатар | 46.5% | 4.2% | 20.5% | 0.0% | 4.7% | 70.6% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

| 2024 | Улсын дунд эзлэх хувь | Чанар, дунд эзлэх хувиар | | | | | Чанар, Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Олон улсын | Улсын | Бүсийн | Аймаг, нийслэлийн | Сум, дүүргийн | |
| Баруун | 8.9% | | 30.1% | 1.6% | 43.6% | 24.7% | 100.0% |
| Хангайн | 22.1% | | 1.6% | 1.5% | 47.1% | 49.9% | 100.0% |
| Төвийн | 18.0% | 0.2% | 3.7% | 0.9% | 73.0% | 22.3% | 100.0% |
| Зүүн | 2.1% | | 6.3% | 3.1% | 58.1% | 32.6% | 100.0% |
| Улаанбаатар | 48.9% | 5.6% | 17.3% | | 4.7% | 72.4% | 100.0% |
| **Бүгд дүн** | **100.0%** | - | - | - | - | - | |

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд Улаанбаатар, Орхон, Өвөрхангай, Төв, Баянхонгор болон Архангай аймгуудаас хамгийн олон тооны оролцогчид хамрагдсан бол Сүхбаатар, Хэнтий болон Баян-Өлгий аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад цөөн тооны оролцогчид бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 15. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, аймаг, нийслэлээр




2024 он




2023 он




2022 он

Аймаг, нийслэл чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Улаанбаатар, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Дорноговь, Баянхонгор болон Архангай аймгууд, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Улаанбаатар болон Орхон, Увс аймгууд тэргүүлж байна.

ЗУРАГ 16. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, чанараар




2024 он




2024 он







2023 он







2022 он

# ХАВСРАЛТ

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/104 тоот тушаалаар батлав.

А-БТС-1

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИДЫН 2024 ОНЫ МЭДЭЭ

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн эцсийн мэдээг дараа оны 2-р сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахим шуудан болон маягтаар ирүүлнэ.

| Бүс, аймаг, нийслэл | МД | Биеийн тамир, спортын байгууллага | Ажиллагчид-Бүгд | | Албан тушаалаар | | | | | | | | Хөгжлийн бэрхшээл-тэй | Эмэгтэй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
